



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А-297

Улаанбаатар хот

Дотоодын банкнаас Монголбанкинд  
гадаад валютын хадгаламж байршуулах  
нөхцөлийг шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8.1, 8.2 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 674 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах нөхцөлийг дор дурдсанаар баталсугай:

- 1.1. Чөлөөтэй хөрвөх валют: Ам.доллар (USD), Евро (EUR);
- 1.2. Хугацаа: Богино хугацаат -7 (долоо) хоногоос 3 (гурван) сар хүртэл;
- 1.3. Хүү: Олон улсын төлбөр тооцооны банкны харгалзах хугацаанд санал болгож буй хугацаат хадгаламжийн өгөөжтэй тэнцүү өгөөж;
- 1.4. Эх үүсвэр: Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх шинж чанартай эсэхийг харгалзан үзэх;
- 1.5. Хэмжээ:  
Дээд хязгаар - Байхгүй  
Доод хязгаар - 10 (арван) сая ам.доллар болон түүнтэй тэнцэх евро;
- 1.6. Хүүний суурь хоног: Хэлцэл нь олон улсын жишиг стандартын дагуу АСТ/360 хоногт суурилна.
- 1.7. Төлбөр тооцоо явагдах зарчим: Хэлцлийн төлбөр тооцоо нь олон улсын жишиг стандартын дагуу t+2 зарчмаар хийгдэнэ.

2. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Тайлан бүртгэлийн газар (Т.Гарьд)-г тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-г даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А-323 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 2361